



ХӨТӨЛ ЦЕМЕНТ ШОХОЙН ХК-ИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ШООВДОР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.19 № 03/20 УАГ-САГ/2013/18 СГА-ГАУГ

Г ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хөтөл цемент шохой ХК-ий 2012 оны санхүүгийн тайланд аудит хийллээ.

Хөтөл цемент шохой ХК 2012 онд Гандан хийдэд хандивт 25,000,000, засал хийлгэхэд 6,500,600 төгрөгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлгүйгээр шилжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-т “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Гүйцэтгэх захиралын Төлөөлөн удирдах зөвлөлтэй 2012 онд байгуулсан гэрээний 3.9-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр компаний эд хөрөнгөөс зээл олгох, бусдад хандивлах, бэлэг өгөх, бусдад хөрөнгийн баталгаа гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээрх хөрөнгийн зарцуулалтын талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлэн цаашид ийм зөрчлийг дахин гаргахгүй байж, биелэлтийг гарган 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Наранчимэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

БИСОФТ АУДИТ ХХК

ЗАХИРАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨТӨЛ ЦЕМЕНТ ШОХОЙ ХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХӨТӨЛ ЦЕМЕНТ ШОХОЙ ХК-ИЙ ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

А.ШООВДОР

Д.НАРАНЧИМЭГ

Л.ОДГЭРЭЛ

С.АНДРУШ

СЭЛЭНГЭ АЙМАГ

ШОХОЙ

070056